

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/4/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Улаанбаатар хот 2026 он</p>	<p>Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261628 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа Цахим хаяг: dabq.audit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
3.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа	11
3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	12
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	14
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	14
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	14
3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Төв албаны санхүүгийн тайланд хийсэн аудит	21
5.1.1 Албан шаардлага	21
5.2 Салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит	22
5.2.1 Албан шаардлага	22
5.2.2 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	26

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
БЗТХҮТ	Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төв
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НЭҮХАА	Нэг эх үүсвэрээс худалдан авах арга
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХА	Харьцуулалтын арга
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах герман улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШХА	Шууд худалдан авалт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

“АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВ” ТӨҮГ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.БАТСАЙХАН ТАНАА

2026 03.16 № 06/720
танай _____-ны № _____-г

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 3,482.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд заасан шалгуурыг хангаж ажиллаагүй орлогын төлөвлөгөөг 1,671.0 сая төгрөгөөр тасалсан, зардлыг 1,563.7 сая төгрөгөөр хэтрүүлэн, 1,994.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 124.4 сая төгрөгийн анхны үнэ бүхий 92 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй;
- Дугаарын дуудлага худалдааны орлогоос "Хүүхдийн төлөө сан"-д 151.7 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4, 20.2.10 дахь заалтуудыг зөрчсөн санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлын онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд төвийн оффисын барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, “Стандарт холдинг” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын ажлын гүйцэтгэл 9,642.2 сая төгрөг буюу 35.0 хувьтай байна.

Асуудлын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус төв нь тайлант онд 9 зорилтын хүрээнд нийт 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 49 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 4 арга хэмжээ хэрэгжих шатанд, 12 арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй, биелэлт 88.0 хувьтай гэж үнэлэгдсэн байна.

Ачаа тээврийн 58615, тээврийн зорчигч 37626, хүнс тээврийн 508, тээвэрлэлтийн гэрээгүй нийтийн зорчигч тээврийн 5029, аюултай ачаа /тэсэрч дэлбэрэх бодис/ тээврийн 92 аж ахуйн нэгжийн 1001 тээврийн хэрэгслийг шалгаж, 1206 зөрчилд 138.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь тайлант онд 708673 тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулахаар төлөвлөснөөс 716645 тээврийн хэрэгслийг хамруулж, 101.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд улсын хэмжээнд нийт 45005 тээврийн хэрэгслийг шинээр бүртгэсэн. Энэ нь 2024 оноос 66675 тээврийн хэрэгсэл буюу 148.2 хувь буурсан нь Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын дагуу нийслэл хотод шинээр автомашины дугаар олгохыг зогсоосонтой холбоотой байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



[Handwritten signature] Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,202,085,105.43	7,281,746,670.48
1.1.2	Дансны авлага	92,727,314.40	62,550,852.57
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	6,409,414.21	735,487,810.67
1.1.4	Бусад авлага	7,785,404.79	6,644,521.79
1.1.6	Бараа материал	2,345,994,455.83	2,856,355,298.23
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,509,955,473.46	176,100,675.46
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	33,164,957,168.12	22,271,853,176.20
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	38,060,345,567.18	40,637,294,565.72
1.2.2	Биет бус хөрөнгө	8,735,691,078.94	9,009,106,239.44
1.2.9	Дуусаагүй барилга	-	11,152,967,347.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	46,796,036,646.12	49,646,400,805.16
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	79,960,993,814.24	71,918,253,981.36
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	234,335,615.99	283,859,686.33
2.1.1.3	Татварын өр	428,158,402.68	4,972,073.13
2.1.1.4	НДШ-ийн өр	145,177.44	8,372.72
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	149,929,462.87	145,100,926.09
2.1.1.9	Хойшлогдсон орлого /Хөрөнгө/	243,683,240.97	414,905,923.67
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,056,251,899.95	848,846,981.94
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	4,281,328,603.86	4,096,342,918.80
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	4,281,328,603.86	4,096,342,918.80
2.2	Өр төлбөрийн нийт дүн		
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: а) төрийн	241,840,000.00	241,840,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,131,491,948.04	3,130,461,462.97
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	28,057,707,591.78	28,020,284,925.35
2.3.9	Хуримтлагдсан ашиг /өмнөх үеийн/	31,891,265,305.65	37,575,225,696.28
2.3.10	Хуримтлагдсан ашиг /тайлант үеийн/	11,301,108,464.96	(1,994,748,003.98)
2.3.11	Эздийн өмчийн дүн	74,623,413,310.43	66,973,064,080.62
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	79,960,993,814.24	71,918,253,981.36

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	43,906,898,393.17	33,652,109,912.15
2	Борлуулалтын өртөг	36,181,740,526.09	41,971,473,263.17
3	Нийт ашиг (алдагдал)	7,725,157,867.08	(8,319,363,351.02)
4	Түрээсийн орлого	232,265,557.27	321,975,328.41
5	Хүүний орлого	717,840,802.93	988,101,813.21
7	Зорчигч тээврийн орлого	7,334,578,937.72	7,405,197,915.17
8	Бусад орлого	742,751,716.11	1,061,596,925.62
8.1	Орлогын дүн	9,027,437,014.03	9,776,871,982.41
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	3,179,023,733.36	3,069,194,474.07
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
12.1	Зардлын дүн	3,179,023,733.36	3,069,194,474.07
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	65,858,954.44	(400,780,700.37)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(10,292,750.00)	12,445,811.80
17	Бусад ашиг (алдагдал)	-	5,272,727.27
17.1	Олз, гарзын дүн	55,293,204.44	(383,062,161.30)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	13,628,864,352.19	(1,994,748,003.98)
19	Орлогын татварын зардал	2,327,755,887.23	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	11,301,108,464.96	(1,994,748,003.98)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	11,301,108,464.96	(1,994,748,003.98)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	54,649,736,673.26	44,889,482,437.03
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	51,626,529,925.35	44,884,736,206.03
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	405,000.00	4,746,231.00
1.1.3	Бусад мөнгөн орлого	3,022,801,747.91	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	44,467,514,712.72	56,995,932,138.90
1.2.1	Ажиллагчдад төлсөн	22,227,096,358.40	26,706,241,208.42
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,079,205,186.42	3,451,467,143.43
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	653,159,128.09	440,689,423.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	3,244,605,636.14	3,447,010,055.06
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	805,590,677.82	928,183,454.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	115,758,025.60	122,061,784.70
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,892,778,199.78	5,163,150,776.62
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	83,292,292.00	103,462,336.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,366,029,208.47	16,633,665,957.67
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	10,182,221,960.54	(12,106,449,701.87)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	717,840,802.91	988,101,813.16
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	717,840,802.91	988,101,813.16
2.1.3	Хадгаламж	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,500,609,042.38	4,545,729,911.37
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,460,964,951.47	4,137,866,275.01
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	39,644,090.91	407,863,636.36
2.2.3	Хадгаламж	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,782,768,239.47)	(3,557,628,098.21)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	3,373,465,797.88	6,256,260,634.87
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	537,962,787.88	605,706,402.42
3.2.2	Төлсөн ногдол ашиг	2,835,503,010.00	5,650,554,232.45
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,373,465,797.88)	(6,256,260,634.87)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,025,987,923.19	(21,920,338,434.95)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	24,176,097,182.24	29,202,085,105.43
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,202,085,105.43	7,281,746,670.48

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,149,852,787.34	19,295,044,750.84	34,708,406,294.68	57,395,143,832.86
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	241,840,000.00	3,149,852,787.34	19,295,044,750.84	34,708,406,294.68	57,395,143,832.86
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(18,360,839.30)	-	-	(18,360,839.30)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	8,762,662,840.94	-	8,762,662,840.94
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	11,301,108,464.96	11,301,108,464.96
Зарласан ногдол ашиг	-	-	-	(2,817,140,898.03)	(2,817,140,898.03)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,131,491,948.04	28,057,707,591.78	43,192,373,861.61	74,623,413,401.43
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	33,406,067.12	33,406,067.12
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(1,030,485.07)	-	-	(1,030,485.07)
Залруулсан үлдэгдэл	241,840,000.00	3,130,461,462.97	28,057,707,591.78	43,225,779,928.73	74,655,788,983.48
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	(37,422,666.43)	-	(37,422,666.43)
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	(1,994,748,003.98)	(1,994,748,003.98)
Зарласан ногдол ашиг	-	-	-	(5,650,554,232.45)	(5,650,554,232.45)
2025 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	241,840,000.00	3,130,461,462.97	28,020,284,925.35	35,580,477,692.30	66,973,064,080.62

**Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан**

**2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон**

/мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/ 2025 гүйц	Хувь	2025 төл/ 2025 гүйц	Хувь
<i>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:</i>									
1	а/ Техникийн хяналтын үзлэгийн орлого	м.төг	16,467,002.6	15,700,000.0	15,527,307.4	939,695.2	94.3	172,692.6	98.9
	Тээвэр зохицуулалтын орлого	м.төг	21,697,238.2	19,420,000.0	17,311,228.8	4,386,009.4	79.8	2,108,771.2	89.1
	Хөдөлгөөний хяналт, удирдлагын орлого	м.төг	1,393,588.0	1,530,000.0	1,592,050.4	(198,462.4)	114.2	(62,050.4)	104.1
	Бүртгэлийн үйлчилгээний орлого	м.төг	11,929,085.8	7,600,000.0	6,892,496.3	5,036,589.6	57.8	707,503.7	90.7
	Үйл ажиллагааны бусад орлого	м.төг	1,447,420.8	850,000.0	2,105,899.0	(658,478.2)	145.5	(1,255,899.0)	247.8
2	Нийт орлого	м.төг	52,934,335.4	45,100,000.0	43,428,981.9	9,505,353.6	82.0	1,671,018.2	96.3
3	Нийт зардал	м.төг	39,305,471.1	43,860,000.0	45,423,729.9	(6,118,258.8)	115.6	(1,563,729.9)	103.6
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	3,179,023.7	2,300,000.0	3,069,194.5	109,829.3	96.5	(769,194.5)	133.4
4	Татварын өмнөх ашиг	м.төг	13,628,864.4	1,240,000.0	(1,994,748.0)	15,623,612.4	(14.6)	(3,234,748.0)	(160.9)
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	11,301,108.5	1,116,000.0	(1,994,748.0)	13,295,856.5	(17.7)	(3,110,748.0)	(178.7)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	14,116,456.3	9,944,210.1	9,388,634.3	4,727,822.0	66.5	555,575.8	94.4
	а/ Орлогын татварт	м.төг	2,327,755.9	124,000.0	-	2,327,755.9	-	124,000.0	-
	б/ НӨАТ	м.төг	3,785,373.2	3,180,500.0	2,793,276.5	992,096.7	73.8	387,223.5	87.8
	в/ НДШ	м.төг	3,252,298.1	3,298,880.7	3,755,658.0	(503,359.9)	115.5	(456,777.3)	113.8
	г/ Хүн амын орлогын татвар	м.төг	1,793,965.1	1,658,728.6	1,179,506.4	614,458.7	65.7	479,222.2	71.1
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	м.төг	137,938.2	189,600.0	133,882.6	4,055.5	97.1	55,717.4	70.6
	э/ Тээврийн хэрэгслийн татвар	м.төг	7,153.1	11,600.8	46,434.1	(39,281.0)	649.1	(34,833.3)	400.3
ж/ Бусад татварт (улсын тэмдэгтийн хураамж)	м.төг	2,811,972.8	1,480,900.0	1,479,876.6	1,332,096.2	52.6	1,023.4	99.9	
7	Төрийн өмчийн ногдол ашгийн өглөг	м.төг	2,835,503.0	1,058,369.9	5,650,554.2	(2,815,051.2)	199.3	(4,592,184.3)	533.9
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	845	845	765	80.0	90.5	80	90.5
9	Нийт цалингийн сан	м.төг	24,130,002.5	25,917,634.6	27,930,067.8	(3,800,065.3)	115.7	(2,012,433.2)	107.8
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,379.7	2,556.0	3,042.5	(662.8)	127.9	(486.5)	119.0
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	м.төг	0.74	0.97	1.05	(0.3)	140.8	(0.1)	107.5
12	Хөрөнгө оруулалт	м.төг	7,561,374.1	30,727,881.7	23,981,677.0	(16,420,302.9)	317.2	6,746,204.7	78.0
13	Нийт авлага	м.төг	106,922.1	120,000.0	804,683.2	(697,761.0)	752.6	(684,683.2)	670.6
	Үүнээс: Найдваргүй	м.төг	10,600.0	13,600.0	10,000.0	600.0	94.3	3,600.0	73.5
14	Нийт өглөг	м.төг	5,337,580.5	3,732,560.6	4,945,189.9	392,390.6	92.6	1,212,629.3)	132.5
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	1,056,251.9	180,000.0	848,847.0	207,404.9	80.4	(668,847.0)	471.6
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	4,281,328.6	3,552,560.6	4,096,342.9	184,985.7	95.7	(543,782.4)	115.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний үйл ажиллагаа

МУЗГ-ын 2009 оны 213 дугаар тогтоолоор Тээврийн хэрэгслийн оношилгоо УТҮГ-ыг байгуулж, 2013 оны 336 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь автотээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх, улс, хот хооронд, орон нутгийн нийтийн зорчигч болон ачаа тээвэр, шуудан, жуулчин тээвэрлэлтийн үйлчилгээг улсын хэмжээнд зохицуулах, зохион байгуулах, авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэргэшсэн жолоочийн шалгалт авах, үнэмлэх олгох, авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох, салбарын бүтээгдэхүүн үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийх, чиг үүргийг хэрэгжүүлдэг Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Төв нь эрхэм зорилгоо “Авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлого, зорилтын хүрээнд хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн цогц үйлчилгээг үзүүлэхэд оршино.” гэж тодорхойлсон байна.

Үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Тээврийн ухаалаг системд суурилсан, хямд, хүртээмжтэй, тээврийн бусад төрөлтэй уялдсан тээврийн үйлчилгээг тогтвортой үзүүлж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;
- Тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангасан байдалд тавих хяналтыг дэлхий нийтээр мөрдөж байгаа стандарт, техникийн зохицуулалт, дэвшилтэт технологид нийцүүлж зам тээврийн осол, түүнээс учирч буй хохирлыг бууруулах;
- Хамтын ажиллагааг өргөжүүлж, судалгаа шинжилгээнд үндэслэсэн, эдийн засаг, нийгмийн эрэлтэд нийцсэн, чанартай, шуурхай, аюулгүй, мэргэжлийн өндөр түвшний үйлчилгээг үзүүлж тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх;
- Мэргэжил, ур чадвар, зөв менежмент хосолсон өрсөлдөх чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлэх.

3.2 Төрийн өмчит үйлдвэрийн газрын гадаад, дотоод орчин

Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ нь Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Тайлант хугацаанд төвийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Автотээврийн тухай хууль;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль;

ТӨҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хяналт шинжилгээ, дотоод аудитын алба нь тайлант онд 4 чиглэлээр 46 ажил гүйцэтгэхээр төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар төлөвлөсөн ажлын гүйцэтгэл 90.0 хувь, 12 нэгж, салбарын үйл ажиллагаанд дотоод аудитын хяналт, шалгалт хийж, хотын 3 нэгжид нийт 55

зөвлөмж, Аймаг дахь автотээврийн 3 төв, 1 салбарт нийт 94 зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.

Зам, тээврийн яамны Салбарын хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тус төвийн өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилтэд 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн байдлаар хяналт, шалгалт хийсэн байна. Уг шалгалтаар 2024 оны аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 64.0 хувьтай байгаа тул цаашид хэрэгжилтийг биелүүлэх төлөвлөгөө гарган, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 10/595 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, СТОУС, НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үндсэн зарчмуудад нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Үйлдвэрийн газрын захирлын 2023 оны А/107 дугаар тушаалаар шинэчлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Өмнөх оны аудитаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, заавар журмын дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт зардал гаргахгүйгээр өөрчлөлт хийж, батлуулан мөрдөх зөвлөмж өгсний дагуу өөрийн үйл ажиллагаанд нийцүүлэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 100.1 АТҮТ ТӨҮГ-ын бүтэц, Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хэлтсийн бүтэц, зохион байгуулалт, ажлын чиг үүрэг, 100.2 Шилэн дансны мэдээллийн агуулга, цаглабар, 100.2.1 Анхан шатны баримт бүрдүүлэлт ба түүнд тавигдах шаардлагууд, 100.2.2 Нягтлан бодох бүртгэл хөтлөх ажлын зохион байгуулалт, 100.2.3 Ажил гүйлгээг тохируулж, гүйлгээ баланс гаргах, 100.2.4 Санхүүгийн болон удирдлагын тайлан гаргах бодлогод өөрчлөлт оруулан, төвийн захирлын 2026 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/46 дугаар тушаалаар батлуулсан байна.

Тус ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,042.7 сая төгрөгөөр буюу 10.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	29,202,085.1	7,281,746.7	(21,920,338.4)
Авлага	106,922.1	804,683.2	697,761.1
Бараа материал	2,345,994.5	2,856,355.3	510,360.8
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,509,955.5	176,100.7	(1,333,854.8)

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Үндсэн хөрөнгө	38,060,345.6	40,637,294.6	2,576,949.0
Биет бус хөрөнгө	8,735,691.1	9,009,106.2	273,415.2
Дуусаагүй барилга	-	11,152,967.3	11,152,967.3
Нийт хөрөнгө	79,960,993.8	71,918,254.0	(8,042,739.8)
Богино хугацаат өр төлбөр	662,639.2	288,840.1	(373,799.1)
Урьдчилж орсон орлого	149,929.5	145,100.9	(4,828.5)
Хойшлогдсон орлого	243,683.2	414,905.9	171,222.7
Урт хугацаат өр төлбөр	4,281,328.6	4,096,342.9	(184,985.7)
Эздийн өмч	74,623,413.3	66,973,064.1	(7,650,349.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	79,960,993.8	71,918,254.0	(8,042,739.8)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, дансны авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, урт хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүнгийн дансдуудад өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 7,281.7 сая төгрөг болж 21,920.3 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь нийт орлогын төлөвлөгөө 1,671.0 сая төгрөгөөр тасарч, нийт зардлыг төлөвлөгөөнөөс 1,563.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн, улсын төсөвт 9,388.6 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашгийн өглөг 5,650.6 сая төгрөг тус тус төвлөрүүлснээс шалтгаалсан;
- Дансны авлагын үлдэгдэл 804.7 сая төгрөг болж 697.8 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд зорчигч тээвэр, GPS буюу хөдөлгөөний хяналт, техник хяналтын үзлэгийн орлоготой, нийгмийн даатгалын шимтгэл, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчдаас авах авлага нэмэгдсэнээс шалтгаалсан;
- Бараа материал дансны үлдэгдэл 2,856.4 сая төгрөг болж 510.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд худалдан авсан хангамжийн материал, маягт үнэт цаас 2,729.7 сая төгрөг, шатахуун, сэлбэг 1,435.3 сая төгрөг, нийт 4,165.0 сая төгрөгөөр нэмэгдэж байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан 3,654.6 сая төгрөгөөр хасагдсантай холбоотой;
- Урьдчилж төлсөн зардал/тооцоо дансны үлдэгдэл 176.1 сая төгрөг болж 1,333.9 сая төгрөгөөр буурсан нь Цогт-Цэций салбарын техникийн хяналтын төв, албан тасалгааны барилгын ажил дуусаж дуусаагүй барилга байгууламжид залруулан бүртгэсэнтэй холбоотой;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 40,637.3 сая төгрөг болж 2,576.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд өөрийн хөрөнгөөр худалдан авсан 4,430.9 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 49.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, ТӨБЗГ-ын 2024 оны 753, 2025 оны 361 дүгээр тогтоолоор 293.8 сая төгрөгийн 2 нэр төрлийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан, тайлант онд үндсэн хөрөнгө дансанд капиталжуулан бүртгэсэн 1,020.6 сая төгрөг, нийт 5,794.3 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна, Тухайлбал:
 - ТӨБЗГ-ын 2023 оны 694, 2024 оны 724 дугаар тогтоолоор худалдан авсан 4,430.9 сая төгрөг,
 - ТӨБЗГ-ын 2024 оны 384 дугаар тогтоолоор Баянзүрх техникийн хяналтын үзлэгийн төвд 940.2 сая төгрөг, Замын-Үүд салбарт 30.3 сая төгрөг, Өмнөговь салбарт 28.9 сая төгрөгийн үзлэгийн барилга болон гадна талбайн засварын гүйцэтгэл, тээврийн хэрэгсэл дансанд 21.0 сая төгрөг, тавилга эд хогшил дансанд хасах элэгдлийн дүнтэй байсан 2 хөрөнгөнд 0.2 сая төгрөгийн өртгөөр элэгдлийн залруулга бичилт хийж, нийт 1,020.6 сая төгрөгийг тус тус капиталжуулсан.
 - ТӨБЗГ-ын 2024 оны 753, 2025 оны 361 тогтоолоор "Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төсөл"-ийн хүрээнд бий болсон 249.8 сая төгрөгийн өртөг бүхий барилгыг Цогт-Цэций салбарт, "Монгол тамга" ТӨҮГ-аас 44.0 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн байрыг төв албанд, нийт 293.8 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Үндсэн хөрөнгийн данс балансаас балансад шилжүүлсэн 365.9 сая төгрөг, худалдан борлуулсан 6.8 сая төгрөг, акталж данс бүртгэлээс хассан 661.1 сая төгрөг, нийт 1,033.8 сая төгрөгөөр хөрөнгө буурсан байна.

- Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 9,009.1 сая төгрөг болж 273.4 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан 407.8 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой;
- Богино хугацаат өр төлбөр 288.8 сая төгрөг болж 373.8 сая төгрөгөөр буурсан нь татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулж 423.3 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн;
- Урт хугацаат зээлийн үлдэгдэл 4,096.3 сая төгрөг болж 185.0 сая төгрөгөөр буурсан нь “Тээврийг хөгжүүлэх” төслийн хүрээнд авсан Нордикийн хөгжлийн сангийн зээлийн тайлант үеийн зээл, зээлийн хүүгийн төлбөрт 629.1 сая төгрөгийг төлснөөс шалтгаалсан,
- Эздийн өмч дансны үлдэгдэл 66,973.1 сая төгрөг болж 7,650.3 сая төгрөгөөр буурсан нь хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл данс 1.0 сая төгрөг, эздийн өмчийн бусад хэсэг данс 37.4 сая төгрөг, хуримтлагдсан ашиг данс тайлант оны алдагдал 1,994.7 сая төгрөг, ногдол ашгийн өглөг 5,650.6 сая төгрөгөөр тус тус хасагдсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

ТӨБЗГ-ын 2024 оны 724 дүгээр тогтоолоор тус төвийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 45,100.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 43,860.0 сая төгрөгөөр, 1,240.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 30,727.9 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 43,428.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 45,423.7 сая төгрөгийн зардал гаргаж, 1,994.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Тайлант оны нийт орлогыг 45,100.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс 43,428.9 сая төгрөг буюу 96.3 хувийн гүйцэтгэлтэй, 1,671.1 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө тасарсан байгаа нь Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолын дагуу дугаар олгох бүртгэлийн үйлчилгээг Нийслэлд шилжүүлснээр үйлчилгээний орлого 10.0 хувиар буурсан. Мөн улсын хэмжээнд нүүрс тээврийн экспорт буурсан, хил нэвтрүүлэлт удааширсантай холбоотойгоор зөвшөөрөл олголт багасаж үйлчилгээний хураамж буурсан нь төлөвлөгөөт орлого тасрахад тус тус нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 45,423.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,563.7 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2025 оны 412 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын орон тооны дээд хязгаарыг 765 болгож 80 орон тоогоор бууруулан шинэчилж баталсантай холбоотой ажлаас чөлөөлөгдсөн ажилтнуудад тэтгэмж олгосноос шалтгаалан цалингийн зардал 1,760.3 сая төгрөгөөр, НДШ-ийн зардал 395.5 сая төгрөгөөр хэтэрсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 21 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 31,671.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд 1,240.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 1,994.7 сая төгрөгийн алдагдалтай ажиллажээ. Энэ нь нийт орлогын гүйцэтгэл 1,671.1 сая төгрөгөөр тасарч, зардал 1,563.7 сая төгрөгөөр хэтэрснээс шалтгаалжээ.

ТӨБЗГ-т 2024 оны ногдол ашиг 5,650.6 сая төгрөг, түрээсийн орлогын 40.0 хувь буюу 127.8 сая төгрөгийг тус тус төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

1. Байгууллагын орон тооны цомхотголын талаар:

Монгол улсын хөгжлийн 2026 оны жилийн төлөвлөгөөнд заасан орон тоо бууруулах чиглэл, төсвийн зардлыг хязгаарлах, хэмнэх зорилтын дагуу 9 хувийн цомхотгол хийж, ТӨБЗГ-ын 2025 оны 647 дугаар тогтоолоор 845 байсан орон тоог 765 хүнтэй байхаар шинэчлэн баталсан байна.

2. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын тарифын талаар:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Хөдөлмөрийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын дүрмийн 6.12, Дотоод журмын 4.1.7, 7.7.6, Хамтын гэрээний 2 дугаар зүйлийн 2.15 дугаар заалтыг тус тус үндэслэн ажилтнуудын өдрийн хоолны хөнгөлөлтийг 25.0 мянган төгрөгөөр, унааны мөнгийг 5.0 мянган төгрөгөөр тус тус тооцож баталсан байна. Тайлант онд унаа, хоолны хөнгөлөлтөд нийт 2,579.5 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 2,494.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

3. Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний судалгааны үр дүнгийн талаар:

Ажилтны мэргэжил боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх 2025 оны сургалтын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр баталж, төлөвлөгөөнд тусгасны дагуу MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо, шаардлага сургалт, Observe болон Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам хамтарсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон ISO 45001 стандартын нийцэл сэдэвтэй сургалт, Нийслэлийн прокурорын газрын зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэстэй хамтран “Эрх бүхий албан тушаалтнаас зөрчлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдэвт сургалт, “System center” төвтэй хамтран үйлдвэрийн газрын нэгжийн нийт албан хаагчдыг ISO 27001 стандарт буюу Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны сэдэвт сургалт зэрэг нийт 21 удаагийн сургалтыг зохион байгуулж, 790 ажилтныг хамруулан, нийт 34.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

4. Гадаад томилолт, арга хэмжээний талаар:

Тайлант онд олон улсын ачаа тээвэр болон Улс хоорондын зорчигч тээврийн үйл ажиллагаатай холбогдуулан үйлдвэрийн газрын захирлын баталсан удирдамжийн дагуу БНХАУ болон ХБНГУ-д томилолтоор ажилласан байна. Гадаад томилолтын зардалд нийт 150.0 сая төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 52.4 сая төгрөг зарцуулсан.

5. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай байгуулсан ажил, үйлчилгээний гэрээний талаар:

Тайлант онд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, цаг үеийн мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх зорилгоор хэвлэл мэдээллийн 18 байгууллагатай хамтран ажилласан байна. Үүнд: ТВ-5 телевиз, Авто радио фм 96.3, 24tsag.mn, Arslan.mn, check.mn, equur.mn, ergelt.mn, isee.mn, livetv.mn, news.mn, newspress.mn, newsroom.mn, ubn.mn, zogii.mn, zuv.mn, dobu.mn цахим хуудсуудаар цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээлэл, цаг агаарын сэрэмжлүүлэг, зорчигч тээвэрлэлтийн мэдээ, дуудлага худалдаа, үнэ тарифын талаар нийт 580 мэдээ мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж, хэвлэл мэдээллийн зардалд 110.8 сая төгрөг зарцуулсан байна.

6. Программ хангамжийн бүртгэл, тайлагналын талаар:

Тус төв нь тээврийн хэрэгслийн хяналт, бүртгэл, лавлагаа, техникийн хяналтын үзлэг, зочигч болон ачаа тээврийн бүртгэл, тээврийн хэрэгслийн бүртгэлийн улсын дугаарын цахим дуудлага худалдааны систем, цахим төлбөрийн систем, санхүүгийн программ, мэргэшсэн жолоочийн бүртгэл, онлайн шалгалтын систем зэрэг нийт 1,054.0 сая төгрөгийн өртөгтэй 15 программ хангамжийг үйл ажиллагаандаа ашигладаг байна. Тайлант онд 407.8 сая төгрөгийн өртөгтэй автотээврийн үйлчилгээг цахимжуулахад зориулсан “Автотээврийн нэгдсэн систем”-ийг хөгжүүлж АТҮТ ТӨҮГ-ын ачаа тээврийн хэлтэс, хөдөлгөөн удирдлагын хэлтэс, хяналтын тасаг, санхүү хөрөнгө оруулалт эдийн засгийн хэлтэс, Зам, тээврийн яам, Авилгатай тэмцэх газар, Хил хамгаалах ерөнхий газар, иргэн, тээвэрчлэгч аж ахуйн нэгжүүд ашигладаг байна.

3.6 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь тайлант онд 38,871.2 сая төгрөгийн төсөвтэй 30 худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүнээс 31,671.8 сая төгрөгийн 21 худалдан авалтыг зохион байгуулж 70.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 2. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Үзүүлэлт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		тоо	дүн	тоо	дүн	хувь	тоо	дүн
1	Ажил	9	30,942,050.0	5	27,704,942.0	55.6	4	3,237,108.0
2	Бараа	19	7,229,104.0	15	3,923,964.0	78.9	4	3,305,140.0
3	Үйлчилгээ	2	700,000.0	1	42,884.0	50.0	1	657,116.0
Дүн		30	38,871,154.0	21	31,671,790.0	70.0	9	7,199,364.0

/мянган төгрөгөөр/

Тайлант онд төлөвлөсөн 6,449.1 сая төгрөгийн төсөвтэй 9 худалдан авалт хийгдээгүй байна. Тухайлбал:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т “энэ хуулийн 13.1.1-д заасан хугацаанд худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусгаагүй бол төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн хэмнэлтэд тооцох” гэж заасныг үндэслэн 3,196.1 сая төгрөгийн төсөвтэй 5 худалдан авалтыг цуцалсан;
2. Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд НТШ-ын аргаар худалдан авахаар төлөвлөсөн 668.0 сая төгрөгийн төсөвтэй 2 худалдан авалтыг 2 удаа тендер шалгаруулалт зарласан боловч амжилтгүй болж, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т “Захиалагч энэ хуулийн 24.1-д заасан хугацаанд шийдвэр гаргаагүй бол тухайн төсвийн жилд тухайн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг дахин зохион байгуулахыг хориглоно” гэсэн заалтын дагуу худалдан авалтыг цуцалсан;
3. Баянзүрх дүүрэгт техникийн хяналтын үзлэгийн үйлчилгээний зориулалтаар байр талбай түрээслэх 85.0 сая төгрөгийн төсөвтэй 1 худалдан авалт тендерт оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон;
4. Замын-Үүд суманд техникийн хяналтын үзлэгийн төвийн барилга шинээр барих 2,500.0 сая төгрөгийн төсөвтэй 1 худалдан авалт техникийн нөхцөлөөс шалтгаалан хэрэгжээгүй байна.

Хүснэгт 3. Худалдан авах ажиллагааны хэрэгжилт

№	Худалдан авалт	Төлөвлөгөөний		Гүйцэтгэлийн			Зөрүү	
		Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	Хувь	Тоо	Мөнгөн дүн
1	НТШ	15	37,035,778.0	9	30,746,339.0	60.0	6	6,289,439.0
2	ХА	10	616,296.0	8	417,065.0	80.0	2	199,231.0
3	ШХА	1	18,180.0	1	9,606.0	100.0	-	8,574.0
4	НЭҮХАА	1	650,000.0	-	-	0.0	1	650,000.0
5	Ерөнхий гэрээ	3	550,900.0	3	498,780.0	100.0	-	52,120.0
Дүн		30	38,871,154.0	21	31,671,790.0	70.0	9	7,199,364.0

/мянган төгрөгөөр/

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 37,035.8 сая төгрөгийн 15 худалдан авалтыг НТШ-ын аргаар худалдан авахаар төлөвлөснөөс 30,746.3 сая төгрөгийн 9 худалдан авалтыг зохион байгуулж 60.0 хувийн гүйцэтгэлтэй, 616.3 сая төгрөгийн 10 худалдан авалтыг ХА-аар худалдан авахаар төлөвлөснөөс 417.1 сая төгрөгийн 8 худалдан авалт хийж 80.0 хувийн гүйцэтгэлтэй, 18.2 сая төгрөгийн 1 ШХА хийхээс 9.6 сая төгрөгийн 1 худалдан авалт хийж 100.0 хувийн гүйцэтгэлтэй, 550.9 сая төгрөгийн 3 худалдан авалтыг ерөнхий гэрээгээр авахаар төлөвлөснөөс 498.8 сая төгрөгийн 3 худалдан авалт хийж 100.0 хувийн гүйцэтгэлтэй байна. НЭҮХАА-аар 650.0 сая төгрөгийн 1 худалдан авалт төлөвлөсөн нь хэрэгжээгүй, нийт 38,871.2 сая төгрөгийн 30 худалдан авалт хийхээр төлөвлөснөөс

31,671.8 сая төгрөгийн 21 бараа ажил үйлчилгээ худалдан авч, тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэл 70.0 хувь байна.

Худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд илэрсэн дараах зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Илрүүлэлт: Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах Техник хяналтын үзлэгийн төв болон автобуудлын барилгын зураг төсөл батлагдаагүй нэг арга хэмжээг батлуулсан нь өмнөх аудитаар техникийн нөхцөлөөс шалтгаалж 2 худалдан авалт хэрэгжээгүй зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч баталсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 21 дүгээр зүйлийн 21.2-т "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг" гэж тус тус заасантай нийцэхгүй, "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөж, зохион байгуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төв алба болон салбар нэгжүүдийн санхүүгийн үйл ажиллагаа, үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого, үндсэн хөрөнгийн бүртгэл, ашиглалт, анхан шатны баримтын бүрдүүлэлт, шатахуун, албан томилолтын зардалд тавих хяналтыг тус тус сайжруулах талаарх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор С.Цэнгэлмаа гүйцэтгэж, захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер Д.Эрдэнэчимэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 01/192 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний баталсан төлөвлөгөөний нийт зардлын дүн 43,860.0 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 438.6 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглох зүйлс”-ийг зөрчөөгүй, хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалтуудыг мөрдөж ажилласан бөгөөд зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар илэрсэн 3 зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих нийт 170 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцроосон мэдээлэлгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын нийт 6768 ширхэг мөнгөн гүйлгээний мэдээллийг бүрэн байршуулжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжтой нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Илрүүлэлт 1: Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг тусгасан ч гүйцэтгэлийн хувийг тайлагнаагүй, мөн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай уялдуулаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8-д “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх үзүүлэлтийг Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдтэй уялдуулан дүгнэж ажиллах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 2: Дорнод аймгийн ЗДТГ-ын салбарын хяналт зохицуулалтын хэлтэст автозамын хяналтын улсын байцаагч гэсэн бүтэц орон тоо байна.

Энэ нь Автотээврийн үндэсний төвийн авто тээврийн хяналтын улсын байцаагчийн орон тоотой чиг үүргийн хувьд давхцаж байна. (Дорнод аймаг дахь салбар)

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд (төв)-ийн болон Төрийн байгууллага хоорондын чиг үүргийн давхцал, үр нөлөө сэдэвт нийцлийн аудитад шилжүүлэх зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалтад нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, илрүүлсэн 15,717.4 сая төгрөгийн зөрчлийг асуудлын бүртгэлээр танилцуулж, 7 зөвлөмж хүргүүлсэн. Жилийн эцсийн аудитаар шалгахад 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжүүлээгүй 151.7 сая төгрөгийн 2 зөрчлийг аудитын

тайланд тусгаж зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын салбаруудын 2025 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар илэрсэн төв албаны нийт 11 алдаа, зөрчлөөс 8.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 105.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлж, 441.0 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн. Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт 93.3 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1	Төлбөрийн акт	2	8,714.2	2	8,714.2	100.0
2	Албан шаардлага	4	105,189.1	4	105,189.1	100.0
3	Зөвлөмж	5	441,012.9	4	441,012.9	80.0
Нийт дүн		11	554,916.2	10	554,916.2	93.3

Өмнөх аудитаар техникийн нөхцөлөөс шалтгаалж 2 худалдан авалт хэрэгжээгүй зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлсэн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ нь Төв алба болон аймаг, нийслэлийн 28 салбарын санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнаж байна. Төв алба болон салбар нэгжүүд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 3 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх” гэж заасны дагуу дээрх цаглабарт хугацааг баримталж байгаа нь нэгтгэсэн тайланг бэлтгэх, аудит хийлгэх хуулийн хугацааг баримтлахад хүндрэлтэй нөхцөл үүсгэж байгааг дээд шатны байгууллагын анхааралд хандуулах нь зүйтэй байна.

Дараагийн аудитаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн дараах үйл ажиллагаанд анхаарал хандуулна. Үүнд:

- Салбаруудаас түүвэрлэн сарын төсвийн гүйцэтгэлийн тайлангуудад горим сорил хэрэгжүүлэх;
- Зорчигч болон ачаа тээврийн орлогын гүйцэтгэлд хэрэгжүүлж байгаа дотоод хяналтыг үнэлэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 11,152.9 сая төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан.

Залруулсан алдаа:

- Нэгтгэсэн тайланд Төв албаны дуусаагүй барилга 9,642.2 сая төгрөг, салбарын дуусаагүй барилга 1,510.7 сая төгрөг, нийт 11,152.9 сая төгрөгийг Урьдчилж төлсөн зардал тооцоо дансанд Дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь НББОУС 16.15-д "хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлийг түүний өртгөөр хэмжинэ", 16.6.в "... өртөг гэдэг нь хөрөнгийг олж эзэмшихийн тулд түүнийг худалдан авах эсвэл барьж байгуулах хугацаанд төлсөн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгийн дүн буюу өгсөн бусад зүйлсийн бодит үнэ цэнэ ..", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 3,482.2 сая төгрөгийн 17 зөрчил² илэрсэнд 3,386.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 албан шаардлага хүргүүлж, 95.7 сая төгрөгийн зөрчилд 13 зөвлөмж өгсөн. Үүнд:

- Төв албаны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3,386.5 сая төгрөгийн зөрчил илэрсэнд 3 албан шаардлага хүргүүлсэн.
- Харьяа салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар нийт 95.7 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс 1 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 95.7 сая төгрөгийн 13 зөрчилд зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 3,482.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 438.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төв албаны санхүүгийн тайланд хийсэн аудит

5.1.1 Албан шаардлага

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанаас 7 өдөр хоцроон, Төрийн аудитын байгууллагад 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/192 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 03 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Жилийн эцсийн санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэж Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант оны орлогын гүйцэтгэл 96.0 хувь буюу орлогын төлөвлөгөөг 1,671.0 сая төгрөгөөр тасалсан, зардлыг 1,563.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Эдийн засгийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тайлант онд 1,240.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон боловч 1,994.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дүгээр зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хангаж ажиллаагүй, орлогын төлөвлөгөөг тасалсан, зардлыг хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

3. Тайлант оны дугаарын дуудлага худалдааны орлогын тооцоог шалгахад “Хүүхдийн төлөө сан”-д төвлөрүүлэх орлогыг 151.7 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.4-т “нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Хүүхдийн төлөө сан”-д төвлөрүүлэх орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит

5.2.1 Албан шаардлага

Архангай аймаг дахь салбар: Харилцагчдын тооцоог хооронд нь зөрүүлж бүртгэсэн нь санхүүгийн сахилга батыг алдагдуулж, өглөг болон авлагын дэлгэрэнгүй бүртгэл бодит байдлаас зөрөхөд хүргэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д “үнэн зөв байх”, 8 дугаар зүйлийн 8.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна. Санхүүгийн тайланг цахим хэлбэрээр гаргах тохиолдолд цахим гарын үсэг хэрэглэж баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өглөг, авлагын бүртгэлийг залруулж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав: Үүнд:

1. Санхүүгийн тайлантай холбоотой

Илрүүлэлт 1. Орхон аймаг дахь салбар жилийн эцсийн санхүүгийн тайланг Төрийн аудитын байгууллагад ирүүлэхдээ тодруулга тайланг бэлтгэж ирүүлээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т “Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүнтэй байна:”, 54.4.5-д “санхүүгийн тайлангийн тодруулга”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан

бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн тайланг холбогдох журмын дагуу иж бүрэн бэлтгэн ирүүлж байх.

2. Авлага, өглөгтэй холбоотой

Илрүүлэлт 2. Дорнод аймаг дахь салбар тайлант оны эцэст 1.1 сая төгрөгийн авлага тайлагнасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, өр авлага үүсгэхгүй ажиллах.

3. Үндсэн хөрөнгийн бүртгэлтэй холбоотой

Илрүүлэлт 3; 4. Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч ашиглагдаж байгаа 124.4 сая төгрөгийн анхны үнэ бүхий 92 нэр төрлийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж бүртгээгүй. (*Дорноговь 69.5 сая төгрөг, Сэлэнгэ 54.9 сая төгрөг*)

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д “...ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгийг... акт тогтоон устгаж болно”, 31.3.2-т “...элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг акталж данснаас хасах, эсхүл ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 5. Сэлэнгэ аймаг дахь салбар Алтанбулаг хилийн боомтод ашиглагдаж байсан 35.4 сая төгрөгийн үнэтэй зөөврийн байрны хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д “өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-өөс холбогдох хууль, журмын дагуу хадгалалт, хамгаалалтыг сайжруулж ажиллах.

4. Хөрөнгийн тооллоготой холбоотой

Илрүүлэлт 6. Завхан аймаг дахь салбар үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогын бүртгэл гарын үсгээр дутуу баталгаажсан. Бараа материалын үлдэгдлийг зөрүүтэй гаргасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг чанартай гүйцэтгэж, бараа материалын тайланг үнэн зөв гаргаж байх.

5. Орлогын гүйцэтгэлтэй холбоотой

Илрүүлэлт 7. Дорнод аймаг дахь салбар өөрийн үйл ажиллагааны орлогыг 754.9 сая төгрөгөөр төлөвлөсөн ч гүйцэтгэлээр 741.3 сая төгрөгийг төвлөрүүлж төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ:” гэсний 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эдийн засгийн үндсэн үзүүлэл, зорилтот түвшний хүрэх үр дүнг хангаж ажиллах.

6. Хоол, унааны хөнгөлөлттэй холбоотой

Илрүүлэлт 8. Төв аймаг дахь салбар тээвэр бүртгэлийн мэргэжилтэнд олгосон 4.6 сая төгрөгийн томилолтоос 3 хоногийн хоолны мөнгө болох 0.7 сая төгрөгийг дутуу суутган, хоолны хөнгөлөлтийг давхардуулан олгосон.

Илрүүлэлт 9. Орхон аймаг дахь салбар тайлант онд 1 алба хаагчийн хоол, унааны нэмэгдлийг албан томилолтоор ажилласан хугацаанд нь давхардуулан илүү олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-ын 2.4-д “Албан томилолтоор ажилласан хоногийн тоог албан томилолтоор ажиллуулах шийдвэрт тэмдэглэсэн хуанлийн хоногоор тооцож гаргана. Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ”, 2.2.1-д “унааны зардал”, 2.2.2-т “хоолны зардал” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Албан томилолтоор ажилласан хугацааны хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгохгүй байх.

7. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой

Илрүүлэлт 10. Завхан аймаг дахь салбар шатахуун зарцуулахдаа ямар ажлаар явсан нь тодорхойгүй, томилолтоор явсан ажлын тайлан гаргаагүй 3.1 сая төгрөгийг зарцуулсан нь анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.

Илрүүлэлт 11. Ховд аймаг дахь салбар шатахууны зардалд дотоод хяналт хэрэгжүүлээгүй, шатахуун олгох бичиггүй шатахуун зарцуулж, тайлагнасан.

Илрүүлэлт 12. Орхон аймаг дахь салбар бараа материалын анхан шатны баримтуудад холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахуун зарцуулсан, томилолтоор явсан үедээ холбогдох албан хаагчдаар ажлын тайлан гаргуулж хэвших, бараа материалын орлого зарлагын анхан шатны баримтууд дээр холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж, дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

8. Зардалтай холбоотой

Илрүүлэлт 13. Ховд аймаг дахь салбар албан хаагчид үзүүлсэн буцалтгүй тусламжаас ХХОАТ суутган тооцоогүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д "аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллах.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
								Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Нэгтгэсэн тайланд Төв албаны дуусаагүй барилга 9,642.2 сая төгрөг, салбарын дуусаагүй барилга 1,510.7 сая төгрөг, нийт 11,152.9 сая төгрөгийг Урьдчилж төлсөн зардал тооцоо дансанд Дуусаагүй үйлдвэрлэлээр бүртгэн тайлагнасан байна.	1	11,152,967.3			1	11,152,967.3	1	11,152,967.3				
Дүн		1	11,152,967.3	-	-	1	11,152,967.3	1	11,152,967.3	-	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төв алба												
1	Жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанаас 7 өдөр хоцроон Төрийн аудитын байгууллагад 2026 оны 2 дугаар сарын 24-ний өдөр 01/192 дугаар албан бичгээр ирүүлсэн.	1	-			1	-					
2	Тайлант оны орлогын төлөвлөгөөг 1,671.0 сая төгрөгөөр тасалсан, зардлыг 1,563.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тайлант онд 2,140.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тусгасан боловч 1,994.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	3,234,748.0			1	3,234,748.0					
3	"Хүүхдийн төлөө сан"-д төвлөрүүлэх дугаарын дуудлага худалдааны орлогыг 151.7 сая төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн байна.	1	151,749.0			1	151,749.0					
Төв албаны зөрчлийн дүн		3	3,386,497.0	-	-	3	3,386,497.0	-	-	-	-	-

Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

Салбарууд											
4	Архангай аймаг дахь салбар	1	-			1	-				
5	Дорноговь аймаг дахь салбар	1	69,547.8					1	69,547.8		
6	Дорнод аймаг дахь салбар	2	14,745.7					2	14,745.7		
7	Завхан аймаг дахь салбар	2	3,082.0					2	3,082.0		
8	Сэлэнгэ аймаг дахь салбар	2	-					2	-		
9	Төв аймаг дахь салбар	1	-					1	-		
10	Орхон аймаг дахь салбар	3	-					3	-		
11	Ховд аймаг дахь салбар	2	8,356.3					2	8,356.3		
Салбаруудын зөрчлийн дүн		14	95,731.7	-	-	1	-	13	95,731.7	-	-
Нийт зөрчлийн дүн		17	3,482,228.7	-	-	4	3,386,497.0	13	95,731.7	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Дд	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт (Төв алба)											
1	Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланд арга хэмжээг хэрэгжүүлэх төсвийг тусгасан ч гүйцэтгэлийн хувийг тайлагнаагүй, мөн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай уялдуулаагүй байна.	1	-							1	-
2	Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах Техник хяналтын үзлэгийн төв болон автобуудлын барилгын зураг төсөл бүрэн дуусаагүй, батлагдаагүй байхад 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулж батлуулсан нь өмнөх аудитаар өгсөн техникийн нөхцөлөөс болж 2 худалдан авалтын ажил хэрэгжээгүй зөрчлийг арилгах зөвлөмж хэрэгжээгүй байна.	1	-			1	-				
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт (Салбар)											
3	Дорнод аймаг дахь салбар Дорнод аймгийн ЗДТГ-ын салбарын хяналт зохицуулалтын хэлтэст автозамын хяналтын улсын байцаагч гэсэн бүтэц орон тоо байгаа нь Автотээврийн үндэсний төвийн авто тээврийн хяналтын улсын байцаагчийн орон тоотой чиг үүргийн хувьд давхцаж байна	1	-							1	-
Дүн		3	-	-	-	1	-	2	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 860/А0150053

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цаглабарт хугацаанаас 7 өдөр хоцроон, Төрийн аудитын байгууллагад 2026 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/192 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 03 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Жилийн эцсийн санхүүгийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэж Төсвийн тухай хуульд заасан цаглабарт хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дунгаамаа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ



АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 861/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны орлогын гүйцэтгэл 96.0 хувь буюу орлогын төлөвлөгөөг 1,671,018,105.00 /Нэг тэрбум зургаан зуун далан нэгэн сая арван найман мянга нэг зуун таван/ төгрөгөөр тасалсан, зардлыг 1,563,729,900.00 /Нэг тэрбум таван зуун жаран гурван сая долоон зуун хорин есөн мянга ерөн зуун/ төгрөгөөр хэтрүүлсэн байна. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөнд тайлант онд 1,240,000,000.00 /Нэг тэрбум хоёр зуун дөчин сая/ төгрөгийн ашигтай ажиллагаар тогтоосон боловч 1,994,748,000.00 /Нэг тэрбум есөн зуун ерэн дөрвөн сая долоон зуун дөчин найман мянган/ төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3-т "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг хангаж ажиллаагүй, орлогын төлөвлөгөөг тасалсан, зардлыг хэтрүүлсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дунгаамаа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 862/АД150053

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны дугаарын дуудлага худалдааны орлогын тооцоог шалгахад "Хүүхдийн төлөө сан"-д төвлөрүүлэх орлогыг 151,749,018.00 /Нэг зуун тавин нэгэн сая долоон зуун дөчин есөн мянга арван найман/ төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн. Завсарын аудитаар залруулан бүртгэж тайлагнах тухай зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-т "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.10-т "аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. "Хүүхдийн төлөө сан"-д дугаарын дуудлага худалдааны орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дунгаамаа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ

Н.ДЭЛГЭРМАА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 863/A0150053

Улаанбаатар хот

САГ-2026/4/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны худалдан авалтын төлөвлөгөөнд Дорноговь аймгийн Замын-Үүд суманд баригдах Техник хяналтын үзлэгийн төв болон авто буудлын барилгын зураг төсөл батлагдаагүй нэг арга хэмжээг батлуулсан нь өмнөх аудитаар техникийн нөхцөлөөс шалтгаалж 2 худалдан авалт хэрэгжээгүй зөрчлийг арилгуулахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.3-т "техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "санхүүгийн төлөв, түүний дотор төлөвлөж байгаа ашиг", 44 дүгээр зүйлийн 44.1-д "Захиалагч баталсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөөгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ-ын Гүйцэтгэх захирал /Ц.Батсайхан/, Ерөнхий нягтлан бодогч /С.Дунгаамаа/ нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
Н.ДЭЛГЭРМАА